

2023 онд төслийн хүрээнд хийгдсэн ажлууд

КОЙКА төслөөр баригдах Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилгын эх загвар зураг батлагдсан. Техникийн нөхцөлүүдийг авах хүсэлтийг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д 2023.03.24-ний 110, "Ус сувгийн удирдах газар" ТӨХК-д 2023.03.24-ний 111, "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-д 2023.03.24-ны 112, "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-д 2023.04.03-ны 131 дугаартай албан бичгээр хүргүүлж барилгыг холбоожуулах, цахилгаан эрчим хүчээр хангах, цэвэр, бохир ус, дулааны техникийн нөхцөл батлагдсан. Төслийн барилга баригдах газрын байгаль орчны төлөв байдлын үнэлгээг "Ашид ананда" ХХК-иар гүйцэтгүүлж Нийслэлийн байгаль орчны газраар хянуулж дүгнэлт гаргуулсан. Төслөөр баригдах барилгын ажлын зураг төслийг боловсруулж Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэж ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар 8 дугаар сард батлуулсан. БНСУ-ын Төслийн менежментийн зөвлөх баг, "ГТХЗНТ" УТҮГ хамтран "Төмөр замын аюулгүй байдлын туршилтын системийн үндсэн дизайн" болон одоо байгаа төмөр замын хурдыг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар хэлэлцүүлгийг 2023.06.27-ны өдөр, төслийн мастер төлөвлөгөөний дундын тайланг танилцуулах арга хэмжээг 2023.06.28-ны өдөр зохион байгуулж Койка, "МТЗ" ТӨХК, "УБТЗ" ХНН, "ТТЗ" ХХК, "МТЛ" ХХК, "Монголиантранс ложистик" ХХК оролцсон. Төслийн менежментийн зөвлөх баг "УБТЗ" ХНН-ийн гол шугам замын тээх нэвтрүүлэх чадварыг сайжруулах судалгаа хийж, төслийн мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд хийсэн төслийн дундын тайлантай ЗТХЯ, ГТХЗНТ танилцаж 2023.08.31-ний 370 дугаартай албан бичгээр Kogail-д хүргүүлсэн.